

**ОЛОН НИЙТИЙН СҮЛЖЭЭНД ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
БОЛОН ДАГАЛДАН ГАРСАН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ
ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ТАТВАРЫН
ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИУДАД БҮХЭЛД НЬ
ТАВЬСАН МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГИЙГ ХЭЛЭЛЦСЭН
ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 03 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан журмын дагуу 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах явцад иргэд, олон нийтийн оролцоог хангаагүй, мэргэжлийн болон судалгааны байгууллагаар хэлэлцүүлж санал аваагүй нь хориг тавих үндэслэл болсон тухай дурдаад Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль нийгэмд зайлшгүй хэрэгцээтэй төдийгүй иргэд цахим гэмт хэргийн хохирогч болж байгаа учраас иргэд, олон нийтийн оролцоог хангаж, эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн байгууллагын саналыг авч дахин батлах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр буюу 100 хувийн саналаар Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль болон дагалдан гарсан Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудад бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.ЭНХБАЯР